



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/104/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjiddmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261740 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК
Захирал: Б.Жаргалсайхан
Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
4.1 Байгууллагын үйл ажилагаа	15
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	15
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	16
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
5.1 Шилэн дансны мэдээлэл	18
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
8. Аудитын илрүүлэлт	19
8.1 Албан шаардлага	19
8.2 Зөвлөмж	19
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
ЗАХИРАЛ Д.СҮРЭНЧИМЭГ
ТАНАА

2022.03.15 № 07/546
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Удирдлагын академийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Удирдлагын академийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд орлого 1,077.2 сая төгрөг буюу 16.2 хувиар өссөн нь ажил олгогч төрийн албан хаагчид төлбөртэй сургалтанд хамрагдаж байгаагаас шалтгаалж өссөн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан бөгөөд аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 106.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,787,248,721.58</u>	<u>9,750,487,361.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,563,983,428.04	9,231,537,376.96
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,220,050.00	
31110	Төгрөг	3,220,050.00	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,831,119,537.15	5,242,198,668.38
3121	Төгрөг	3,831,119,537.15	5,242,198,668.38
31213	Арилжааны банк дахь харилцах	3,831,119,537.15	5,242,198,668.38
31500	Хадгаламж	3,729,643,840.89	3,989,338,708.58
33	АВЛАГА	16,100,212.20	5,803,249.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	528,749.20	954,749.20
335	Бусад авлага	15,571,463.00	4,848,500.00
3351	Байгууллагаас авах авлага	11,521,463.00	4,848,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,050,000.00	
34	УРЬДЧИЛГАА	86,745,000.00	396,688,950.00
3471	Урьдчилгаа тооцоо	86,745,000.00	396,688,950.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	86,745,000.00	17,957,500.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		362,731,450.00
34714	Томилолтын урьдчилгаа		16,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	120,420,081.34	116,457,785.34
351	Түүхий эд материал	13,027,670.00	17,845,440.00
35110	Тусгай зориулалттай материал	13,027,670.00	17,845,440.00
354	Хангамжийн материал	107,392,411.34	98,612,345.34
35410	Бичиг хэргийн материал	62,276,270.00	50,663,270.00
35420	Аж ахуйн материал	45,116,141.34	47,949,075.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,092,448,130.95</u>	<u>8,385,555,639.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,092,448,130.95	8,385,555,639.15
392	Биет хөрөнгө	6,301,165,657.54	6,530,402,342.45
39201	Барилга. байгууламж. орон сууц	5,215,826,661.96	5,029,640,784.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(651,405,304.22)	(795,058,517.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,196,000.00	60,012,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,437,389.18)	(44,767,389.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,082,336,712.00	1,760,102,182.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(328,822,063.01)	(442,477,011.96)
39207	Тавилга. аж ахуйн эд хогшил	955,646,807.96	1,001,283,003.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(312,336,158.48)	(353,817,370.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	178,677,138.80	179,309,138.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(55,158,616.47)	(68,253,895.14)
39217	Ном	194,641,868.18	204,429,418.18
393	Биет бус хөрөнгө	1,791,282,473.41	1,855,153,296.70
39301	Програм хангамж	61,182,070.00	123,884,930.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(31,143,896.59)	(33,928,733.30)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,279,136,300.00	2,279,136,300.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(517,892,000.00)	(513,939,200.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II	<u>15,879,696,852.53</u>	<u>18,136,043,000.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,586,451,653.00</u>	<u>1,436,583,009.30</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,586,451,653.00	1,436,583,009.30
413	Өглөг	23,231,153.00	31,618,489.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,867,304.00
4136	Бусад өглөг	23,231,153.00	29,751,185.30
41361	Байгууллагад төлөх өглөг	23,231,153.00	29,751,185.30
414	Урьдчилж орсон орлого	1,563,220,500.00	1,404,964,520.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	1,563,220,500.00	1,404,964,520.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>14,293,245,199.53</u>	<u>16 699 459 991.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	14,293,245,199.53	16,699,459,991.3
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,922,018,782.44	3,922,018,782.44
51101	Өмч: - төрийн	3,922,018,782.44	3,922,018,782.44
512	Хуримтлагдсан үр дүн	6,992,109,588.45	9,315,530,380.27
51210	Өмнөх үеийн үр дүн	4,029,103,101.04	6,993,641,288.45
51220	Тайлант үеийн үр дүн	2,963,006,487.41	2,321,889,091.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,379,116,828.64	3,461,910,828.64
6	ӨР ТӨЛБӨР. ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>15,879,696,852.53</u>	<u>18,136,043,000.65</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,324,546,570.67	7,711,794,389.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,519,033,870.67	3,650,255,049.45
120	Нийтлэг татварын бус орлого	4,519,033,870.67	3,650,255,049.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,514,810,911.67	3,650,255,049.45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,742,439,313.00	3,277,998,783.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	506,526,098.67	371,961,265.85
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,265,845,500.00	295,000.00
120005	Түрээсийн орлого	3,934,220.00	
120009	Бусад орлого	288,739.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,805,512,700.00	4,061,539,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,805,512,700.00	4,061,539,340.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,805,512,700.00	4,061,539,340.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,356,510,083.26	5,348,789,250.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,356,510,083.26	5,348,789,250.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,267,702,593.26	5,294,326,530.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,649,073,558.75	2,731,785,272.65
210101	Үндсэн цалин	2,495,119,125.21	2,557,712,257.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,278,523.54	131,197,445.32
210105	Гэрээт ажлын хөлс	27,675,910.00	42,875,570.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	330,138,833.07	353,555,416.98
210201	Тэтгэврийн даатгал	330,138,833.07	353,555,416.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,186,500.00	223,289,340.00
210301	Гэрэл, цахилгаан	68,161,500.00	60,048,740.00
210302	Түлш, халаалт	116,845,000.00	128,062,700.00
210303	Цэвэр, бохир ус	30,180,000.00	35,177,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,588,124.17	85,254,684.00
210401	Бичиг хэрэг	27,715,124.50	18,418,467.00
210402	Тээвэр, шатахуун	12,774,321.00	17,746,906.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,335,654.67	32,381,540.00
210404	Ном, хэвлэл	2,236,300.00	4,316,271.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,000,000.00	12,391,500.00
210408	Бараа материал акталсны зардал	28,526,724.00	
2105	Нормативт зардал	28,499,625.00	18,719,317.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,499,625.00	18,719,317.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	613,662,299.00	476,106,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,530,404.00	4,737,590.00
210604	Урсгал засвар	599,131,895.00	471,368,910.00
2107	Томилолт, зочны зардал	28,903,950.00	12,118,930.00
210701	Гадаад албан томилолт	14,217,190.00	12,008,930.00
210702	Дотоод албан томилолт	8,056,040.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,630,720.00	110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил. үйлчилгээний төлбөр, хураамж	672,918,358.65	664,702,767.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	658,275,268.65	639,928,087.20

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	24,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	789,220.00	774,680.00
210807	Газрын төлбөр	1,853,870.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	606,731,344.62	728,794,302.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,211,800.00	1,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105,444,382.00	79,471,758.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл,хорогдол	498,075,162.62	647,522,544.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,807,490.00	54,462,720.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,807,490.00	54,462,720.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,356,250.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж. шагнал урамшуулал	70,451,240.00	54,462,720.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,968,036,487.41</u>	<u>2,363,005,139.37</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,030,000.00	41,116,047.55
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		41,116,047.55
225002	Найдваргүй авлагын алдагдал	5,030,000.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,030,000.00)	(41,116,047.55)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,963,006,487.41</u>	<u>2,321,889,091.82</u>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,922,018,782.44	3,379,116,828.64	4,026,048,221.51	11,327,183,832.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,054,879.53	3,054,879.53
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,922,018,782.44	3,379,116,828.64	4,029,103,101.04	11,330,238,712.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			2,963,006,487.41	2,963,006,487.41
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,922,018,782.44	3,379,116,828.64	6,992,109,588.45	14,293,245,199.53
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,922,018,782.44	3,379,116,828.64	9,955,116,075.86	14,293,245,199.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,531,700.00	1,531,700.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,922,018,782.44	3,379,116,828.64	6,993,641,288.45	14,294,776,899.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		82,794,000.00		82,794,000.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			2,321,889,091.82	2,321,889,091.82
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,922,018,782.44	3,461,910,828.64	9,315,530,380.27	16,699,459,991.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>7,457,008,841.90</u>	<u>7,697,112,595.77</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,651,496,141.90	3,635,573,255.77
120	Нийтлэг татварын бус орлого	3,651,496,141.90	3,635,573,255.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,651,496,141.90	3,635,573,255.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,065,587,111.00	3,098,224,403.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	510,874,821.64	370,014,573.69
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	75,034,209.26	167,334,278.48
13	ТУСЛАМЖ. САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,805,512,700.00	4,061,539,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,805,512,700.00	4,061,539,340.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,805,512,700.00	4,061,539,340.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,964,091,230.35</u>	<u>5,132,844,236.85</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,964,091,230.35	5,132,844,236.85
210	БАРАА. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,875,283,740.35	5,078,381,516.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,649,073,558.75	2,730,679,572.65
210101	Үндсэн цалин	2,495,119,125.21	2,556,606,557.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,278,523.54	131,197,445.32
210105	Гэрээт ажлын хөлс	27,675,910.00	42,875,570.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	330,138,833.07	353,555,416.98
210201	Тэтгэврийн даатгал	330,138,833.07	353,555,416.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,186,500.00	223,289,340.00
210301	Гэрэл, цахилгаан	68,161,500.00	60,048,740.00
210302	Түлш, халаалт	116,845,000.00	128,062,700.00
210303	Цэвэр, бохир ус	30,180,000.00	35,177,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,256,209.67	84,670,298.00
210401	Бичиг хэрэг	26,506,105.00	19,016,660.00
210402	Тээвэр, шатахуун	14,400,000.00	16,251,327.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,335,654.67	32,381,540.00
210404	Ном, хэвлэл	3,014,450.00	4,629,271.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,000,000.00	12,391,500.00
2105	Нормативт зардал	30,943,189.00	13,379,810.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,943,189.00	13,379,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	688,740,396.00	813,670,481.00
210601	Багаж, Техник, хэрэгсэл	20,981,796.00	370,286,250.00
210602	Тавилга	905,000.00	
210604	Урсгал засвар	666,853,600.00	443,384,231.00
2107	Томилолт, зочны зардал	45,098,370.00	28,118,930.00
210701	Гадаад албан томилолт	14,217,190.00	28,008,930.00
210702	Дотоод албан томилолт	12,106,040.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	18,775,140.00	110,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил. үйлчилгээний төлбөр, хураамж	703,513,646.86	722,619,190.22
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	688,870,556.86	697,844,510.22
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	24,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	789,220.00	774,680.00
210807	Газрын төлбөр	1,853,870.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,333,037.00	108,398,478.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,211,800.00	1,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	114,121,237.00	106,598,478.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,807,490.00	54,462,720.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,807,490.00	54,462,720.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,356,250.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,451,240.00	54,462,720.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,492,917,611.55</u>	<u>2,564,268,358.92</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	366,235,514.00	896,714,410.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	366,235,514.00	896,714,410.00
2200	Дотоод эх үүсвэрээр	366,235,514.00	896,714,410.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	366,235,514.00	896,714,410.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(366,235,514.00)</u>	<u>(896,714,410.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,126,682,097.55	1,667,553,948.92
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,437,301,330.49	7,563,983,428.04
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,563,983,428.04	9,231,537,376.96

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,330,326,744.35	6,634,639,500.00	6,029,558,646.85	(605,080,853.15)	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,330,326,744.35	6,634,639,500.00	6,029,558,646.85	(605,080,853.15)	90.9
210	БАРАА. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,241,519,254.35	6,540,249,000.00	5,975,095,926.85	(565,153,073.15)	91.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,649,073,558.75	2,736,600,000.00	2,730,679,572.65	(5,920,427.35)	99.8
210101	Үндсэн цалин	2,495,119,125.21	2,535,000,000.00	2,556,606,557.33	21,606,557.33	100.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,278,523.54	165,000,000.00	131,197,445.32	(33,802,554.68)	79.5
210105	Гэрээт ажлын хөлс	27,675,910.00	36,600,000.00	42,875,570.00	6,275,570.00	117.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	330,138,833.07	369,441,000.00	353,555,416.98	(15,885,583.02)	95.7
210201	Тэтгэврийн даатгал	330,138,833.07	369,441,000.00	353,555,416.98	(15,885,583.02)	95.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,186,500.00	257,165,200.00	223,289,340.00	(33,875,860.00)	86.8
210301	Гэрэл. цахилгаан	68,161,500.00	83,841,200.00	60,048,740.00	(23,792,460.00)	71.6
210302	Түлш. халаалт	116,845,000.00	118,116,000.00	128,062,700.00	9,946,700.00	108.4
210303	Цэвэр. бохир ус	30,180,000.00	55,208,000.00	35,177,900.00	(20,030,100.00)	63.7
2104	Хангамж. бараа материалын зардал	104,346,468.67	115,408,900.00	94,457,848.00	(20,951,052.00)	81.9
210401	Бичиг хэрэг	26,506,105.00	27,825,000.00	19,016,660.00	(8,808,340.00)	68.3
210402	Тээвэр. шатахуун	14,400,000.00	17,149,500.00	16,251,327.00	(898,173.00)	94.8
210403	Шуудан. холбоо. интернэтийн төлбөр	33,335,654.67	36,854,400.00	32,381,540.00	(4,472,860.00)	87.9
210404	Ном. хэвлэл	12,104,709.00	14,500,000.00	14,416,821.00	(83,179.00)	99.4
210405	Хог хаягдал зайлуулах. хортон мэрэгчдийн устгал. ариутгал	18,000,000.00	19,080,000.00	12,391,500.00	(6,688,500.00)	64.9
2105	Нормативт зардал	30,943,189.00	35,550,000.00	13,379,810.00	(22,170,190.00)	37.6
210503	Нормын хувцас. зөөлөн эдлэл	30,943,189.00	35,550,000.00	13,379,810.00	(22,170,190.00)	37.6
2106	Эд хогшил. урсгал засварын зардал	910,149,460.00	2,036,720,500.00	1,700,597,341.00	(336,123,159.00)	83.5
210601	Багаж. техник. хэрэгсэл	145,747,956.00	1,349,422,300.00	1,170,227,910.00	(179,194,390.00)	86.7
210602	Тавилга	35,285,400.00	38,000,000.00	27,973,000.00	(10,027,000.00)	73.6
210604	Урсгал засвар	729,116,104.00	649,298,200.00	502,396,431.00	(146,901,769.00)	77.4
2107	Томилолт. зочны зардал	45,098,370.00	60,500,000.00	28,118,930.00	(32,381,070.00)	46.5
210701	Гадаад албан томилолт	14,217,190.00	30,500,000.00	28,008,930.00	(2,491,070.00)	91.8
210702	Дотоод албан томилолт	12,106,040.00	20,000,000.00		(20,000,000.00)	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	18,775,140.00	10,000,000.00	110,000.00	(9,890,000.00)	1.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил. үйлчилгээний төлбөр. хураамж	703,513,646.86	736,376,000.00	722,619,190.22	(13,756,809.78)	98.1

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	688,870,556.86	722,422,000.00	697,844,510.22	(24,577,489.78)	96.6
210802	Аудит. баталгаажуулалт. зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00	24,000,000.00	12,000,000.00	200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	789,220.00	980,000.00	774,680.00	(205,320.00)	79.1
210807	Газрын төлбөр	1,853,870.00	974,000.00		(974,000.00)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	253,069,228.00	192,487,400.00	108,398,478.00	(84,088,922.00)	56.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,211,800.00	14,200,000.00	1,800,000.00	(12,400,000.00)	12.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	249,857,428.00	178,287,400.00	106,598,478.00	(71,688,922.00)	59.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,807,490.00	94,390,500.00	54,462,720.00	(39,927,780.00)	57.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,807,490.00	94,390,500.00	54,462,720.00	(39,927,780.00)	57.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,356,250.00	21,380,000.00		(21,380,000.00)	
213209	Нэг удаагийн тэтгэмж. шагнал урамшуулал	70,451,240.00	73,010,500.00	54,462,720.00	(18,547,780.00)	74.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,457,008,841.90	6,634,639,500.00	7,697,112,595.77	1,062,473,095.77	116.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,805,512,700.00	4,095,415,200.00	4,061,539,340.00	(33,875,860.00)	99.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	3 805 512 700.00	4 095 415 200.00	4 061 539 340.00	(33 875 860.00)	99.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,651,496,141.90	2,539,224,300.00	3,635,573,255.77	1,096,348,955.77	143.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,065,587,111.00	2,297,208,300.00	3,098,224,403.60	801,016,103.60	134.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	510,874,821.64	242,016,000.00	370,014,573.69	127,998,573.69	152.9
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	75,034,209.20		167,334,278.48	167,334,278.48	
4	Мөнгө. түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			7,563,983,428.04	7,563,983,428.04	
5	Мөнгө. түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			9,231,537,376.96	9,231,537,376.96	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	101	130	103	(27)	79.2
620001	Удирдах ажилтан	9	9	9		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	74	103	76	(27)	73.8
620003	Үйлчлэх ажилтан	18	18	18		100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	101	130	103	(27)	79.2
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	101	130	103	(27)	79.2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Удирдлагын академийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдэлт, авлагын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 3 дугаар сарын 10-ны хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Наранчимэг, захирал Б.Жаргалсайхан нар хэрэгжүүлсэн.

Удирдлагын академийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 01/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Удирдлагын академийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус академийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Удирдлагын академийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардал 5,356.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 53.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Удирдлагын академи нь сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээ, төрийн албан хаагчдыг мэргэшүүлж бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, төрийн албаны хүний нөөцийн менежментийн асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр, төр, захиргааны байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Засгийн газрын харъяа төрийн албаны сургалтын байгууллага юм.

Тус байгууллагын дүрэмд чиг үүргийн дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Засгийг газар, төрийн бусад байгууллагын захиалгаар сургалт эрхлэн явуулна;
- Академи нь эрхлэн гүйцэтгэх сургалтын агуулга, хөтөлбөр хэлбэр, үргэлжлэх хугацааг холбогдох хууль тогтоомж, өөрийн орны онцлог, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдөнө;
- Судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж зөвлөх үйлчилгээ үзүүлнэ;
- Засгийн газрын захиалгаар гүйцэтгэх сургалтын агуулга, хөтөлбөрийн Төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамран батлана;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Удирдлагын академи нь Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ны 197 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагын удирдлагыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас томилдог байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу нийт төсвийн зардлыг 9.1 хувиар, цалин, тэтгэмжийн зардлын хассан урсгал үйл ажиллагааны төсвийг 16 хувиар хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Удирдлагын академийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,564.0	9,231.5	1,667.5
Авлага	16.1	5.8	(10.3)
Урьдчилж төлсөг зардал / тооцоо/	86.7	396.7	310.0
Бараа материал	120.4	116.4	(4.0)
Үндсэн хөрөнгө	6,301.1	6,530.4	229.3
Биет бус хөрөнгө	1,791.3	1,855.2	63.9
Нийт хөрөнгийн дүн	15,879.6	18,136.0	2,256.4
Өр төлбөрийн дүн	1,586.4	1,436.6	149.8
Богино хугацаат өглөг	1,586.4	1,436.6	149.8
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	14,293.2	16,699.4	2,406.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,879.6	18,136.0	2,256.4

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 5,242.2 сая төгрөг, Голомт банк дахь хадгаламж 3,989.3 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд байгууллагаас авах авлага 4.8 сая төгрөг, ажилчдаас авах авлага 1.0 сая төгрөг байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө бэлтгэхэд 362.7 сая төгрөг, гадаад томилолтонд 16.0 сая төгрөг, ажил үйлчилгээнд 17.9 сая төгрөгийг тус тус урьдчилгаа дансанд бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд бичиг хэргийн материал 50.6 сая төгрөг, хангамжийн материал 47.9 сая төгрөг, түүхий эд материал 17.8 сая төгрөг байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд тоног төхөөрөмж 721.8 сая төгрөг, тавилга хэрэгсэл 89.2 сая төгрөг, ном хэрэгсэл 9.8 сая төгрөг, программ хангамж 78.1 сая төгрөг, нийт 898.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. ТӨБЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 527 тоот тогтоолоор 186.2 сая төгрөгийн дотуур байрны зориулалттай барилгыг акталж бүртгэлээс хассан. Мөн ТӨБЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 196 тоот тогтоолоор 170 нэрийн 211.4 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн 82.8 сая төгрөгөөр дахин үнэлж, ашиглагдах хугацааг шинээр тогтоосон байна. Дахин үнэлсэн хөрөнгөнд 31.4 сая төгрөгийн 1 ширхэг тээврийн хэрэгсэл, бусад нь тоног төхөөрөмж, тавилга, аж ахуйн эд хогшил, бусад үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгүүд байна.

Биет бус хөрөнгө данс өмнөх оноос 76.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь программ виртуал сервер 26.5 сая төгрөг, программ виртуал клиент сервер 27.4 сая төгрөг, Office 365 программ 11.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж авснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 31.6 сая төгрөг нь засвар үйлчилгээ хийсэн ажлын барьцааны өглөг үүссэнээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар Удирдлагын академийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд орлогыг улсын төсвөөс 4,124.5 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,443.2 сая төгрөг, нийт 5,567.7 сая төгрөг төвлөрүүлж зарцуулахаар тогтоож, 2021 оны 5 сард нэмэлт тодотголоор сургалтыг цахимаар явуулж байгаатай холбоотой багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг нэмэгдүүлж орлогыг улсын төсвөөс 4,124.5 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2,539.2 сая төгрөг, нийт 6,663.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Улсын төсвөөс хийгдэх санхүүжилт нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцад “Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил” хөтөлбөрийн санхүүжилт гэж тусгагддаг байна.

Нийт орлогын гүйцэтгэл 7,711.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,077.2 сая төгрөг буюу 16.2 хувиар төлбөртэй сургалтын төлбөрийн орлого төлөвлөснөөс давж биелүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 7,711.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,389.9 сая төгрөгийн зардал гарган, 2,321.9 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь 4,061.5 сая төгрөгийн орлого улсын төсвөөс олгосон санхүүжилтээс, 3,650.3 сая төгрөгийн орлого байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос тус тус бүрджээ.

Тус академи тайлант хугацаанд 7,697.1 сая төгрөгийн нийт мөнгөн орлого, 6,029.5 сая төгрөгийн нийт мөнгөн зарлагын гүйцэтгэлтэй ажилласан байна.

Нийт мөнгөн орлогын гүйцэтгэлийн 4,061.5 сая төгрөг буюу 52.8 хувийг ЗГХЭГ-аас захиалгат сургалт, судалгаа болон тогтмол зардалд урсгал төсвийн санхүүжилтээр, 3,098.2 сая төгрөг буюу 40.2 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 537.3 сая төгрөг буюу 7.0 хувийг туслах үйл ажиллагааны болон бусад орлогоор тус тус бүрдүүлжээ.

Улсын төсвөөс 2021 онд 4,095.4 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс 4,061.5 сая төгрөгийн санхүүжилт авч 33.9 сая төгрөгийн дутуу санхүүжилт нь тогтмол зардлын хэмнэлтээс үүссэн байна.

Нийт мөнгөн зардлын гүйцэтгэлийн 3,084.2 сая төгрөг буюу 51.1 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 223.3 сая төгрөг буюу 3.7 хувийг тогтмол зардал, 107.8 сая төгрөг буюу 1.8 хувийг бичиг хэрэг, ном хэвлэл худалдан авах, тээвэр шатахуун, шуудан холбоо гэх мэт хангамж үйлчилгээний болон нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал, 722.6 сая төгрөг буюу 12.0 хувийг эрдэм шинжилгээ, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын болон бусад төлбөр тооцооны зардал, 1,700.6 сая төгрөг буюу 28.2 хувийг урсгал засвар, эд хогшил худалдан авах зардал, 28.1 сая төгрөг буюу 0.5 хувийг гадаад, дотоод томилолт, зочны зардал, 108.4 сая төгрөг буюу 1.8 хувийг хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний зардал, үлдсэн 54.5 сая төгрөг буюу 0.9 хувийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал тус тус эзэлж байна.

Зардлын зүйл анги, бүлгийн дүнгээр бүх зардал хэмнэлттэй гарсан байна. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Удирдлагын академи нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах мэдээллүүдээ иж бүрэн мэдээллэсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байсан.

Тус байгууллагын захирал нь ковид цар тахлын нөхцөл байдал, цахимаар ажиллах ажлын ачаалал ихэссэн зэргийг харгалзан багш, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тушаал гаргаж академийн бүх ажилтнуудад 1 сарын "нэмэлт цалин" олгосон байгааг Удирдлагын академийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, багш, ажилтан, ахмад настанд тусламж дэмжлэг үзүүлэх журам зэрэгт тусгайлан тодорхойлж заагаагүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 0.4 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1 зөрчлийн залруулж, 0.4 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлага, 1 зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна.

Үзүүлэлт	/мянган төгрөг/						
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	6,100.0	2	6,100.0			
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	3	6,100.0	3	6,100.0			

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын захирлыг томилсон албан тушаалтан нь академийн захирлын ажлын үр дүнг харгалзан шагнах, биеэр эдлээгүй амралтын мөнгөн урамшуулал нөхөн олгох зэрэг асуудлыг шийдвэрлээгүйн улмаас захирал нь зайлшгүй ажлын шаардлагаар биеэр эдэлж чадаагүй ээлжийн амралтын цалин, мөн ковид цар тахлын нөхцөл байдал, цахимаар

ажиллах ажлын ачаалал ихэссэн зэргийг үндэслэн 1 сарын нэмэлт цалинг тус тус авсан зэргийг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.4 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 3.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 3.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 53.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшинээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Албан шаардлага

1. Тус байгууллагын захирал нь зайлшгүй албан шаардлагын улмаас ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй нэр бүхий 6 ажилтанд ээлжийн амралтын цалинг нь нөхөн олгохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээгүй байгаа заалтыг үндэслэн 1.5 дахин нэмэгдүүлж 0.7 сая төгрөг олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Нийтийг хамарсан хөл хорионы үед нэг удаагийн сургалтад зориулан ажлын хувцсаар жигдрэх шийдвэр гаргаж, нийт 2,310,000.00 төгрөгийн хувцас захиалан хийлгэсэн байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь сургалтын төлбөрийн орлогыг ерөнхий журналд бөөн дүнгээр бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3-"Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх", 14.3.4."Ажил, гүйлгээний мэдээ гаргах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг мөрдөж ажиллах, сургалтын төлбөрийн орлогыг нэг бүрчлэн бүргэж байх

2. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Касснаас зарцуулсан сургалтанд хэрэглэгдэх хангамжийн материалыг бэлдэхдээ бараа материалын дансанд орлого авч, зарцуулаагүй, НӨАТ болон ХХОАТ-ын тооцоонуудыг холбогдох стандартын дагуу бүртгээгүй бөөн дүнгээр бичилт хийж байна. Тухайн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дээрх асуудлыг шийдвэрлээгүй ба бусад холбогдох хууль эрх зүй, дүрэм журмын өөрчлөлтийг захирлын тушаалаар нэмэлт сайжруулалт хийж шинэчлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн

хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг дагаж мөрдөх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагынхаа онцлог, холбогдох хууль тогтоомж, стандарт дүрэм журам зааварт нийцүүлэн боловсруулж батлуулан мөрдөж ажиллах

3. Зардлын ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2021 оны 06 дугаар сарын 30-нд касснаас Эрдмийн зөвлөлийн зардалд 0.1 сая төгрөгийн цай кофе зэрэг хангамжийн материал, 2021оны 06 дугаар сарын 15-нд касснаас Эрдмийн зөвлөлийн хурлын зардалд 0.4 сая төгрөг тус тус "Норм, хувцас, зөөлөн эдлэл" зардлын ангиллаас тус тус бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан журамд заасан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг дагаж мөрдөх, зардал хооронд гүйлгэхгүй байх

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын захирлын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/116 дугаартай тушаалаар "2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нд нээлттэй тендер шалгаруулалт 8, харьцуулалтын аргаар 7, гэрээт ажил үйлчилгээ нэрээр 3 худалдан авах ажиллагааг зохион байгуулна гэж төлөвлөсөн байна. Харин Төрийн худалдан авах ажиллагааны системийн төлөвлөгөө хэсэгт 9 худалдан авах ажиллагааг мэдээллэж, 7 худалдан авах ажиллагааны урилгыг байршуулсан буюу бүрэн мэдээллээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийг мөрдөж ажиллах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний дагуу зарласан урилгуудаа худалдан авах ажиллагааны цахим системд зарлан мэдээллэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Удирдлагийн академи	АХГ-2022/104/НА-СТА-ТӨА	Зайлшгүй албан шаардлагын улмаас ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй нэр бүхий 6 ажилтанд ээлжийн амралтын цалинг нь нөхөн олгоходоо хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээгүй байгаа заалтыг үндэслэн 1.5 дахин нэмэгдүүлж олгосон байна.	Төлбөрийн барагдуулах цаашид алдааг давтан гаргахгүй байх.	1	725.8							1	725.8		
2	Удирдлагийн академи	АХГ-2022/104/НА-СТА-ТӨА	Нийтийг хамарсан хөл хорионы үед нэг удаагийн сургалтад зориулан ажлын хувцсаар жигдрэх шийдвэр гаргаж, нийт 2,310.0 мянган төгрөгийн хувцас захиалан хийлгэсэн байна.	Цаашид алдааг давтан гаргахгүй байх.	1	2,310.0							1	2,310.0		
3	Удирдлагийн академи	АХГ-2022/104/НА-СТА-ТӨА	Сургалтын төлбөрийн орлогыг ерөнхий журналд бөөн дүнгээр бүртгэсэн	Сургалтын төлбөрийн орлогыг нэг бүрчлэн ерөнхий журналд бүртгэх												1
4	Удирдлагийн академи	АХГ-2022/104/НА-СТА-ТӨА	Каснаас зарцуулсан сургалтанд хэрэглэгдэх хангамжийн материалыг бэлдэхдээ бараа материалын дансанд орлого авч, зарцуулаагүй, НӨАТ болон ХХОАТ-ын тооцоонуудыг холбогдох стандартын дагуу бүртгээгүй бөөн дүнгээр бичилт хийж байна. Тухайн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дээрх асуудлыг шийдвэрлээгүй ба бусад холбогдох хууль эрх зүй, дүрэм журмын өөрчлөлтийг захирлын тушаалаар нэмэлт сайжруулалт хийж шинэчлээгүй байна.	НББББ-ыг холбогдох стандарт дүрэм, журам болон үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах												1

5	Удирдлагын академи	АХГ-2022/104/НА-СТА-ТӨА	Зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан	Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах, зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх	1	429.1								1	429.1
ДҮН					5	3,464.9					2	3,025.8		3	429.1
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
6	Удирдлагын академи	АХГ-2022/104/НА-СТА-ТӨА	Тус байгууллагын захирлын 2021.05.24-ний өдрийн А/116 дугаартай тушаалаар "2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нд нээлттэй тендер шалгаруулалт 8, харьцуулалтын аргаар 7, гэрээт ажил үйлчилгээ нэрээр 3 худалдан авах ажиллагааг зохион байгуулна гэж төлөвлөсөн байна. Харин Төрийн худалдан авах ажиллагааны системийн төлөвлөгөө хэсэгт 9 худалдан авах ажиллагааг мэдээллэж, 7 худалдан авах ажиллагааны урилгыг байршуулсан буюу бүрэн мэдээллээгүй байна.		1									1	
ДҮН					1									1	
НИЙТ ДҮН					6	172,112.1					2	3,025.8		4	429.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 332/А 015 0054

Улаанбаатар хот

АХГ-2022/104/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8 заалтын дагуу Удирдлагын академийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын захирлын тушаалаар албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй нэр бүхий 6 ажилтанд ээлжийн амралтын цалинг нөхөн олгохдоо хүчин төгөлдөр мөрдөж эхлээгүй хуулийн заалтыг үндэслэн 1.5 дахин нэмэгдүүлж, 725,208.00 төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг, нягтлан бодогч С.Алтансүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.МӨНХЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 08 дугаар сарын 15

№ 333/1130054

Улаанбаатар хот

ХТ-2022/104111-СТГ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Удирдлагын академийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийтийг хамарсан хөл хорионы үед нэг удаагийн сургалтад зориулан ажлын хувцсаар жигдрэх шийдвэр гаргаж, нийт 2,310,000.00 төгрөгийн хувцас захиалан хийлгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг, нягтлан бодогч С.Алтансүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Г ГҮНЖИДМАА
А МӨНХЦЭЦЭГ